



БАГАХАНГАЙ ДУУРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 1/24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигийн хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 21 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, холбогдох мэдээ, тайлан ирүүлэх хугацааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бусад хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагуудаас ирүүлсэн мэдээ мэдээллийг нэгтгэн, тогтоосон хугацаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэг (А.Сүхболд)-т харицуулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

ДАРГА

Ф.МОНХГЭРЭЛ



НВСДАУУЧДЫН

Нийслэлийн Багахангай дуургийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023.оны 07. сарын 07.-ны өдрийн
~~11/24~~ дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛД ТАНИЛЦУУЛАХ
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ ХУГАЦАА**

№	Мэдээ ирүүлэх байгууллага, хэлтэс, албад	Мэдээлэл	Хугацаа
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Нийгмийн хөгжлийн хэлтэс	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагын байршил, тоо (бүртгэлтэй, зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй), шашны урсгалын мэдээ	Жил бүрийн 6 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 20
2	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Цэргийн штаб, Цагдаагийн хэлтэс	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээ тайлан	Жил бүрийн 11 дүгээр сарын 20
3	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Гадаад улсын элчин сайд болон бусад төлөөлөгчидтэй уулзсан уулзалтын ярианы тэмдэглэл, байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичиг	Тухай бүр
4	Нийгмийн хөгжлийн Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс	Амьдрах орчны аюулгүй байдал хэрхэн хангаж байгаа талаарх мэдээ	Жил бүрийн 11 дүгээр сарын 20
5	Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс	Ус хангамжийн эх үүсвэр, нөөц, чанар, усны байгууламж, ашиглалт, хамгаалалт (зураглал, зурган мэдээний хамт)	Жил бүрийн 11 дүгээр сарын 20
6	Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс	Усны сан бухий газрын хамгаалалтын тухай (зураглал, зурган мэдээний хамт) бүсийн дэглэмийн	Жил бүрийн 11 дүгээр сарын 20
7	Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс	Агаарын чанарын төлөв байдал, бохирдлыг бууруулах арга хэмжээний тухай мэдээ	Жил бүрийн 11 дүгээр сарын 20
8	Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс	Хатуу, аюултай хог хаягдал, түүний менежмент тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын

			20
9	Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс	Гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн шилжилт хөдөлгөөн, үйл ажиллагааны тухай мэдээ	Жил бүрийн 6 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 20
10	Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Эрүүл мэндийн төв	Дүүргийн хүн ам, байгал орчинд аюул, эрсдэл учруулж болохуйц нөхцөл байдал, үйл явцын тухай мэдээ	Тухай бүр
11	Улсын бүртгэлийн хэлтэс	Хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн судалгаа	Жил бүрийн 6 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 20
12	Газар зохион байгуулалтын алба	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт, газрын нэгдмэл сан, газрын төлөв байдал (зураглал, зурган мэдээний хамт	Жил бүрийн 11 дүгээр сарын 20